

ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ, КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЦААШИД ХУУЛЬ ГЭХ/
ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ, БУСАД
ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, "ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН ДҮРЭМ БОЛОН ЭНЭХҮҮ
ДҮРМЭЭР КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛНА.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
дугаар: 3012/0700/1
2015 оны 4 сарын 27-ны өдөр
Бүртгэсэн: Улсын (адгаж) бүртгэгчийн
гарын үсэг

"Шивээ-Овоо" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн
хурлаар батлав.

"ШИВЭЭ-ОВОО" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

/шинэчилсэн найруулга/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. "Шивээ-Овоо" компани нь нээлттэй хувьцаат компани /цаашид "компани" гэх/
мөн.

1.2. Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, /цаашид хууль гэх/,
Хүний хөгжил сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад
холбогдох хууль тогтоомж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм болон энэхүү
дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.

1.3. Компанийн оноосон албан ёсны нэрийг (монголоор)

• бүрэн нэр: "ШИВЭЭ-ОВОО" Хувьцаат компани

• товчилсон нэр: "ШОХК"

• англиар: "SHIVEE-OVOO" Joint stock company гэнэ.

1.4. Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Говьсүмбэр
аймаг, Шивээговь сум, 1-р баг.

1.5. Компани нь өөрийн бэлэгдэл /эмблем/, барааны тэмдэг, албан бичгийн
х эвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг /тамга/ хэрэглэнэ. Бэлэгдэл,
барааны тэмдгийг Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг
хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.

1.6. Компани нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл
ажиллагаагаа хугацаагүй явуулна.

1.7. Компани нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын салбарт
үйл ажиллагаа явуулах, үр ашгийг нэмэгдүүлэх, Хүний хөгжил сангийн эх
үүсвэрийг бүрдүүлэх чиг үүрэг бүхий компанийн нэгдлийн оролцогч компани мөн.

1.8. Компанийн төрийн мэдлийн хувьцааг эзэмшигч нь "Эрдэнэс Монгол"
ХХК /цаашид "толгой" компани гэх/ байна.

1.9. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа
явуулах бөгөөд нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангана.

1.10. Толгой компани нь хууль тогтоомж болон энэхүү дүрмээр
тодорхойлсон бүрэн эрхэд нь хамааруулснаас бусад асуудлаар компанийн өдөр

тутмын үйл ажиллагаанд шууд оролцохгүй бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээнд нийцүүлэн санал гаргана.

1.11 Компани нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэм болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

/1.7-1,11 заалтуудыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн. /

ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

2.1. Компани нь үүсгэн байгуулагдсан үеэсээ хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2. “Шивээ-Овоо” хувьцаат компани нь Компанийн тухай Монгол улсын хуулийн дагуу зохион байгуулагдсан, үүсгэн байгуулагчдын оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг, бие даасан тайлан тэнцэлтэй, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

2.3. Компани нь өөрийн тусгаарласан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ. Компани нь банкинд төгрөгийн, гадаад валютын болон бусад данстай байна. Компани нь шүүх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.

2.4. Компани нь өөрийн материаллаг болон мөнгөн хөрөнгөтэй байх ба тэдгээрийг ашиглах, захиран зарцуулах болон бусад эрхийг эдэлнэ.

2.5. Хувьцаа эзэмшигчид Компанийн хариуцлагыг хүлээхгүй ба Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй болно.

2.6. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

2.7. Компани нь Монгол улсын хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.

ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.1. Компани нь хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн үр ашигтай бизнес эрхлэхийг үндсэн зорилго болгон дараах чиглэлийн үйл ажиллагаа эрхлэн явуулна:

3.1.1. үйлдвэрлэл /ашигт малтмал олборлох, боловсруулах/;

3.1.2. гадаад, дотоод худалдаа /уул уурхайн үйлдвэрийн машин техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн/;

3.1.3. эдгээрээс гадна хуулиар хориглоогүй үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэнэ/-ийн шийдвэрээр явуулж болно

3.2. Компанийн эрхэм зорилго: "Байгаль орчинд ээлтэй, аюулгүй үйлдвэрлэл, өндөр бүтээмж бүхий уул уурхайн салбарын жишиг үйлдвэр болно"

3.3. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн явуулна.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

4.1. Компанийн зарласан хувьцаа нэг бүр нь 100 төгрөгийн үнэ нэрлэсэн үнэ бүхий 13,419,101 ширхэг энгийн хувьцаа байна. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн гаргасан хувьцааг анхдагч зах зээл дээр худалдах үед хувьцаа эзэмшигчдийн худалдан авсан үнийн дүнтэй тэнцүү байна.

4.2. Компанийн зарласан хувьцаанаас гүйлгээнд нэмж гаргах болон бусад үнэт цаас гаргах шийдвэрийг ТУЗ гаргана. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт гаргах үнэт цаасны төрөл, тоо ширхэг, нэрлэсэн үнэ, үнийн дүн, төвлөрүүлсэн хөрөнгийн зориулалт, үнэт цаасыг нийтэд эсхүл хаалттай захиалгаар худалдах эсэх, тэдгээрийг худалдан авсан этгээдийн эдлэх эрх болон энгийн хувьцаанаас бусад үнэт цаас нь энгийн хувьцаанд хөрвөх эсэх, хөрвөх бол хөрвөх нөхцөл зэргийг заасан байна.

4.3. Энгийн хувьцааг компанийн давуу эрхийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хөрвүүлж үл болно.

4.4. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнэлгээг уг хэлцэл хийхийг сонирхогч бус ТУЗ ийн гишүүд санал нэгтэй тогтооно. Үнэлгээг тогтоохдоо мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэс болгоно.

4.5. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэртэсэн бол Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу бүртгүүлэх, Хөрөнгийн биржид бүртгүүлэх, нийтэд сурталчилах, андеррайтер болон зуучлах үнэт цаасны компанитай гэрээ байгуулан ажиллах асуудлыг Гүйцэтгэх захирал хариуцан зохион байгуулна.

4.6. Хувьцаа бусад үнэт цаасны үнийг хуулийн 55-р зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.

4.7. Компани гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авсан бол эдгээр хувьцааг халаасны хувьцаа гэх бөгөөд балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэгт нэрлэсэн үнээр нь хасах тэмдэгтэйгээр харуулна.

4.8. Компанийн нийт хөрөнгөнөөс өр төлбөрийг хассан дүн өөрийн

бүрт өөрчлөгдөнө.

4.9. Жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс бага болсон тохиолдолд ТУЗ нь ийнхүү бага болсон шалтгааныг судлан, дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлнэ.

4.10. Шинээр хувьцаа гаргаж хөрөнгө оруулбал тэр хэмжээгээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны тоо нэмэгдэнэ.

4.11. Цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаад үлдсэн ашгийн хэмжээгээр компанийн өөрийн хөрөнгө нэмэгдэх бөгөөд хувьцааны тоо өөрчлөгдөхгүй.

4.12. Алдагдал гарсан, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг устгасан, найдваргүй авлагыг данснаас хассан зэрэг тохиолдолд тэр хэмжээгээр компанийн хуримтлагдсан ашиг болон өөрийн хөрөнгө буурна. Хувьцааны тоо болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй.

4.13. Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө ба хувьцааны балансын үнэ нэмэгдэж, хорогдоно.

4.14. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж хорогдуулж болно.

4.14.1. хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх, нэгтгэх;

~~4.14.2. хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөлгүйгээр хувьцааг хуваах;~~

~~4.14.3. хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох.~~

ТАВ. ХАРААТ БОЛОН ОХИН КОМПАНИ, САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

5.1. Компани нь дангаараа болон бусад хуулийн этгээдтэй хамтран хараат болон охин компанийг байгуулан ажиллуулж болно. Хараат болон охин компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн үүрэг хүлээх хуулийн этгээд байна.

5.2. Хараат болон охин компанийг хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид ХЭХ гэнэ/-ын шийдвэрээр байгуулах ба үйл ажиллагаа нь тухайн компанийн дүрмээр зохицуулагдана.

5.3. Компани нь Улаанбаатар хотод Төлөөлөгчийн газартай байна. Шаардлагатай тохиолдолд шинээр салбар, төлөөлөгчийн газрыг өөр газарт ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болно.

5.4. Төлөөлөгчийн газар нь компанийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлсөн үйл ажиллагааг явуулна. Салбар нь компанийн үндсэн үйл ажиллагааг түүний нэрийн өмнөөс өөр газар нутагт явуулдаг этгээд байна.

5.5. Санбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулна. Тэдгээр нь компанийн албан бичгийн хэвлэмэл хуудас, санбар, төлөөлөгчийн газрын тэмдэг хэрэглэнэ.

5.6. Санбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилж чөлөөлөх бөгөөд тэдгээр нь компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

6.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь хуулийн 34, 35 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрхийг эдэлнэ:

6.1.1. компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцлөөр тэргүүн ээлжинд худалдан авах;

6.1.2. компани нь ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн шийдвэрт заасан хугацаанд ногдол ашиг хуваарилах бөгөөд хугацаанд нь төлөөгүй тохиолдолд алданги нэхэмжлэх;

6.1.3. хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, 53.2-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;

6.1.4. хувьцаа эзэмшигч нь ээлжит хурал хуралдах үед хуулийн 65.6-д заасан баримт бичигтэй танилцах;

6.1.5. компанийн энгийн хувьцааны нэг болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтны буруугаар компанид болон өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;

6.1.6. компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчийн шаардсанаар ХЭХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг танилцуулах;

6.1.7. ХЭХ, түүний шийдвэрийн талаар хуулийн 70 дугаар зүйлд заасан үндэслэлээр холбогдох байгууллагад гомдол гаргах;

6.2. Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй:

6.2.1. өөрийн эрхийн хүрээнд олж мэдсэн компанийн болон бусад хувьцаа эзэмшигчдийн нууцыг "Байгууллагын болон Хувь хүний нууцын гухай" хуулийн дагуу хадгалж, хамгаалах үүрэгтэй;

6.2.2. энэ дүрмийн 6.1.3-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмыг хангаж ажиллах;

6.2.3. компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчийн бүртгэлд өөрийн нэр, хаягаа бүртгүүлэх үүрэгтэй.

6.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд ганцхүү өөрийн эзэмшиж байгаа хувьцааныхаа хэмжээгээр эрсдэл хүлээнэ.

6.4. Дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр хариуцна.

ДОЛОО. НОГДОЛ АШИГ

7.1. ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

7.2. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:

7.2.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

7.2.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;

7.2.3. компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

7.3. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт хуваарилах ногдол ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр, ногдол ашиг төлж эхлэх өдөр, зэрэг мэдээллийг тусгасан байна.

7.4. ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй. Компани нь ногдол ашиг хуваарилахдаа ТУЗ-өөс батлагдсан "Ногдол ашиг хуваарилах журам"-ыг баримтална.

7.5. Ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг хуулийн 64 дүгээр зүйлд заасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлох бөгөөд энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

7.6. Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна.

7.7. Компани ногдол ашгаа заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

7.8. Хуулийн 46.10-т заасан хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл тухайн компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

7.9. Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани нь хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

7.10. Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж,

Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хөрөө болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

7.11. ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд тайлагнана.

7.12. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

7.13. Компани эргүүлэн худалдаж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

НАЙМ. КОМПАНИ ӨӨРИЙН ГАРГАСАН ҮНЭТ ЦААСЫГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ

8.1. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр ТУЗ-ийн шийдвэрээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дундажийн 25 хувиас илүүгүй байна.

8.2 Компани өөрийн гаргасан энгийн хувьцааны таваас дээш хувийг худалдан авах шийдвэрийг гаргахдаа хуулийн 49.10 дугаар заалтыг мөрдөнө.

8.3. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

8.4. Компани дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн авах шийдвэр гаргаж болно:

8.4.1. эргүүлэн авах үүрэг бүхий энгийн хувьцааг эргүүлэн авах;

8.4.2. үнэт цаасаа эргүүлэн авсаны дараа төлбөрийн чадвартай байх;

8.4.3. компанийн өөрийн хөрөнгө нь гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байх.

8.5. Компани өөрийн давуу эрхийн хувьцааг эргүүлэн худалдаж авахдаа хуулийн 50 дугаар зүйлийг баримтлана.

ЕС. ХУВЬЦААНЫ ХЯНАЛТЫН БАГЦЫГ ХУДАЛДАЖ АВАХ

9.1. Хувьцаат компанийн энгийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах хүсэлтэй этгээд нь хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу энэ тухайгаа нийтэд мэдээлэх замаар худалдан авах санал гаргана.

9.2. Энэ дүрмийн 9.1-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд энэ асуудлаар ХЭХ-аас тусгайлан шийдвэр гаргаагүй бол хувьцаа эзэмшигчид дээрхи этгээдэд хувьцаагаа худалдахад нь компанийн зүгээс саад учруулахгүй байна.

9.3. Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөс хойш ажлын 60 өдрийн дотор бусад хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн зургаан сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй. Уг саналаа Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу гаргана.

9.4. Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ дүрмийн 9.3-д заасан саналыг гаргаагүй бол уг саналыг гаргаж, зохих журмын дагуу хэрэгжүүлэх хүртэл тухайн этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй байна.

9.5. Энэ дүрмийн 9.3-д заасны дагуу бусад хувьцаа эзэмшигчийн хувьцааг худалдан авах саналыг ХЭХ-ын зар хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

9.6. Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ дүрмийн 9.3-д заасан саналыг гаргахдаа уг саналыг хаах хугацааг олон нийтэд саналаа зарласнаас хойш 30-аас доошгүй хоног байхаар тогтооно.

9.7. Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь хуулийн 58.1-д заасны дагуу нийтэд мэдэгдэнэ.

АРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

10.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. ХЭХ нь ээлжит болон ээлжит бус байна.

10.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна. Энэ хугацаанд хурлыг хуралдуулаагүй бол ТУЗ-ийн ХЭХ хуралдуулахаас бусад хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.

10.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуулийн 61.1-д заасан тохиолдолд ТУЗ, эсхүл мөн хуулийн 61.7-д заасан этгээд хуралдуулах тухай шийдвэрийг гаргана.

10.4. ХЭХ-ыг удирдах этгээдийг тухайн хурлыг зарласан этгээд хурал хуралдуулах шийдвэрт заана.

10.5. ХЭХ хуралдуулах тухай шийдвэрт хуулийн 60.2-т заасан зүйлийг тусгана.

10.6. ХЭХ хуралдуулах шийдвэр гарснаас хойш тав хоногийн дотор ХЭХ-ын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргэх бөгөөд шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.

10.7. Компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үнд хувьцаа эзэмшигчдэд дараах мэдээллийг танилцуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй:

10.7.1. компанийн санхүүгийн жилийн тайлан;

10.7.2. санхүүгийн жилийн тайлангийн талаарх нудитын байгууллагын дүгнэлт;

10.7.3. тайлангийн жилд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд;

10.7.4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга;

10.7.5. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;

10.7.6. ТУЗ-ийн цалин урамшуулал;

10.7.7. бизнесийн үйл ажиллагааны тайлан.

10.8. Ээлжит бус хурлыг хуралдуулах асуудлыг хуулийн 61.2-61.10-д заасны дагуу зохион байгуулна.

~~10.9. Тухайн санхүүгийн жилийн 12 дугаар сард багтаан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж Компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батална.~~

~~/Энэ заалтыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн./~~

~~/10.9 дэх заалтыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

10.10. Хуулийн 62.1-д заасан болон дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

10.10.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

10.10.2. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

10.10.3. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

10.10.4. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

10.10.5. хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцэл болон арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ баталж чадаагүй бол тэдгээрийг хэлэлцэж батлах;

10.10.6. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

10.10.7. хуулийн 96.4-т заасан тайлан;

10.10.8. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

10.10.9. хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

~~10.10.10. Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг батлах;~~

~~/Энэ заалтыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 06-тоот тогтоолоор нэмсэн./~~

/10.10.10 дахь заалтыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./

10.11. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд санал оруулах асуудлыг хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

10.12. ХЭХ-ын тооллогын комисс байгуулах болон ажиллах журмыг хуулийн 67 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

10.13. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно. ХЭХ-аар хэлэлцэж байгаа асуудлыг шийдвэрлэхэд нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.

10.14. Компанийн ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах бүх асуудлыг /ТУЗ-ийн гишүүдийг сонгохоос бусад/ хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

~~10.15. ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар санал хураан сонгох бөгөөд ингэхдээ саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрх бүхий хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо нэр дэвшигчээс хамгийн олон санал авсан хүнийг сонгоно.~~

10.16. Компанийн ХЭХ-д оролцох эрх, хурлын зар мэдээг хүргэх, хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах, хурлын тооллогын комисс томилох, хуралд оролцох журам, хурлын ирц, хурал хүчин төгөлдөр болох, санал авах хуудсыг хүчинтэйд тооцох, эчнээ санал хураалтаар компанийн хувьцаа эзэмшигчид шийдвэр гаргах, ХЭХ-ын тэмдэглэл хөтлөх зэрэг асуудлуудыг хуулийн 63-74 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.

10.17. ХЭХ хуралдуулах тухай шийдвэр гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлын товыг тогтоосноос хойш ХЭХ-аар яаралтай хэлэлцэж шийдвэрлэх асуудал гарсан тохиолдолд хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор уг асуудлыг хэлэлцэхээр шийдвэр гаргаж болно.

10.18. Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдахгүйгээр хувьцаа эзэмшигчээс эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу явуулна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

10.19. ХЭХ-ын тэмдэглэлийг хуулийн 74.2-д зааснаар хөтөлж хадгална.

АРВАН НЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

11.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөө цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэг нь хараат бус гишүүн байна.

11.2. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

11.2.1. компанийн нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй;

11.2.2. компанид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй;

11.2.3. төрийн үйлчилгээнээс бусад алба хашдаггүй;

11.2.4. компанитай бизнесийн холбоогүй байх;

11.2.5. компанийг удирдах мэргэжлийн өндөр ур чадвартай.

11.3. Хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй байна:

11.3.1. ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих;

11.3.2. дээр дурьдсан зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгах шаардлага тавих, эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар ХЭХ-ыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх, компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

11.3.3. ХЭХ-д биечлэн оролдож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

11.4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооноос холбогдох хууль, журамд заасны дагуу нэрийг нь дэвшүүлсэн хүнийг ХЭХ-аар хэлэлцэж томилно.

11.5. ТУЗ нь хуулийн 76 дугаар зүйлд заасан болон дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.5.1. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох;

11.5.2. компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал урамшууллын хэмжээг тогтоох;

11.5.3. компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцлийг тогтоох;

11.5.4. компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

11.5.5. ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тогтоох;

11.5.6. төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг батлах;

11.5.7. их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

11.5.8. сонирхолын зөрчил бүхий хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

11.5.9 Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлах;

/11.5.9 дэх заалтыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. /

11.6. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг түр томилно.

11.7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

11.8. ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар ТУЗ-ын даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос сонгоно.

11.9. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүрэг хүлээнэ.

11.10. ТУЗ-ийн ээлжит хурлыг сард 1 удаа хуралдуулна. Ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөлгөөг жилийн эхний хурлаар батална. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хуралдаан хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байх бөгөөд уг тогтоолд ТУЗ-ын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

11.11. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх ба тэмдэглэлд ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурна. Тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлыг удирдсан дарга хариуцна.

11.12. ТУЗ-ийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно. Санал тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

11.13. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.

11.14. Компанийн ТУЗ нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодыг өөрийн дэргэд байгуулан ажиллуулна.

11.15. Хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүн байх бөгөөд эдгээр гишүүдийн гуравны хоёр нь ТУЗ-ийн хараат бус гишүүд байна.

11.16. Хороод нь ТУЗ-ийн баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа явуулах ба жилд 2-оос доошгүй удаа өөрийн үйл ажиллагааныхаа талаар тайлагнах үүрэгтэй.

12.4. Тогтой компани нь компанийн нэгдлийн хамарал бүхий компанийн үйл ажиллагаанд хамаарах асуудлыг зохицуулах үүднээс тэдгээрийн гүйцэтгэх удирдлагуудын хүрээнд зөвлөл ажиглуулна. Зөвлөлийн үйл ажиллагааны журмыг гүйцэтгэх удирдлагууд болон тогтой компанийн төлөөлөн

12.3. Тогтой компани нь компанитай компанитай тухай хууль, тогтой компанитай дүрмийн дагуу өөрийн төлөөлөөр дамжуулан харилцахаас гадна Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газар, төрийн захираганы байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэн гэрээ байгуулан хамтран ажиглаж болно.

12.2. Тогтой компани нь компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигчийн хувьд компанитай холбоотой гаргасан аливаа шийдвэрээ компанитай нийт ангийн хувьцааны нэг /1-ээс дээш хувийг дангаараа эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй.

12.1. Компанийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг тогтой компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс эрх олгосон эрх бүхий албан тушаалтан болон тогтой компанийн гүйцэтгэх захирал хамтран

эрхээ хэрэгжүүлэхэдээ тогтой компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан удирдамжийг баримтлах бөгөөд энэхүү удирдамжаас өөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэслэл болно.

11.17. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь хуулийн 81.4-д заасан чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулан шийдвэр гаргуулна.

11.18. Нэр дэвшүүлэх хороо нь хуулийн 81.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

11.19. Цалин, урамшууллын хороо нь хуулийн 81.6-д заасан чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна.

11.20. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.

11.21. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн эрх бүхий албан тушаалтанд хамрагдах ба хуулийн 82.2-т заагдсан үүргийг биелүүлж ажиглана.

Арван хоёр. Тогтой компани болон компани хороондын харилцаа

/Энэ бүлэг Хувьцаа эзэмшигчийн хуулийн 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 06 дугаар тогтоолоор өөрчлөгдсөн./

12.5.Компани нь аливаа хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эрх бүхий байгууллага, толгой компанийн шийдвэрийн дагуу эзэмшиж болно.

12.6.Компанийн нэгдлийн хоорондын харилцааг уялдуулах үүднээс компанид толгой компани дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

12.6.1.Охин болон хараат компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх болон толгой, охин, хараат компани хоорондын харилцааг зохицуулсан аливаа дүрэм журам, гэрээг батлах;

12.6.2.Компанийн хэвийн үйл ажиллагаа доголдож, санхүүгийн зохистой харьцаа, үзүүлэлт алдагдсан тохиолдолд аудитын дүгнэлтийг үндэслэн үйл ажиллагааг тогтворжуулж, хүндрэлийг даван туулахад чиглэсэн тодорхой төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

12.6.3.Компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн эд хөрөнгө худалдан авах, үндсэн эд хөрөнгийг данснаас хасах актлах асуудлыг толгой компанийн гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн удирдамжийг үндэслэн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ;

12.6.3-дахь заалтыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. /

12.6.4.Худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх,

12.6.5.Хувьцаа эзэмшигчийн эрхийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд хэрэгжүүлэх толгой компанийн эрх бүхий албан тушаалтныг томилох;

12.6.6.Шийдвэрлүүлэхээр ирүүлсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийн талаарх охин компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг хэлэлцэх;

Холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг гаргуулан авах, тайлан тэнцэлтэй танилцах, шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаар шалгуулах.

АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

13.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх захирлыг түүнтэй байгуулах гэрээний үндсэн дээр ТУЗ-өөс томилно.

13.2. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

13.3. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд ТУЗ-ийг төлөөлж ТУЗ-ийн дарга гарын үсэг зурах бөгөөд гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

13.4. Гүйцэтгэх захирал нь түүнтэй байгуулсан гэрээнд тусгасан эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

13.4.1. компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна;

13.4.2. хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулан, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн ба үр дүнгийн гэрээ байгуулна;

13.4.3. компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна;

13.4.4. компанийн дотоод журмыг батална;

13.4.5. өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана;

13.4.6. компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулна;

13.4.7. компанийг төлөөлөх итгэмжлэл олгоно;

~~13.4.8. компанийн ажиллагсдын хөдөлмөрийн сахилга бат, хөдөлмөр хамгаалалтын дэг журмын хэрэгжилт, технологийн горимын хэрэгжилт болон аж ахуй санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалтад хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;~~

13.4.9. Монгол улсын хууль, тогтоомж болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна;

13.4.10. компанийн бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж, ТУЗ-өөр батлуулан, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдын баг бүрдүүлэх;

13.4.11. компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна;

13.4.12. хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангана;

13.4.13. компанийн улирал, жилийн үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн хуралд тайлан тавьж хэлэлцүүлнэ. Энэхүү тайланд тухайн хугацаанд хийсэн гэрээ, хэлцлийн дотор компанийн аль нэг эрх бүхий албан тушаалтны хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх, байсан бол тухайн хэлцлийг Компанийн тухай хуулин 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай асуудлыг тусгасан байна.

13.5. Хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг ТУЗ хэдийд ч гаргах эрхтэй.

АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

14.1. Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, Техникийн асуудал эрхэлсэн дэд захирал, Технологийн бодлогын хэлтсийн дарга, Техникийн бодлогын хэлтсийн дарга, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, Захиргаа, хүний нөөцийн бодлогын хэлтсийн дарга, Худалдаа, хангамжийн хэлтсийн дарга, Хяналтын албаны дарга, Ерөнхий маркшейдер, Ерөнхий цахилгаанчин, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

14.2. Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийн дагуу Гүйцэтгэх захирлын дэргэд түүнд зөвлөх үүрэг бүхий Захирлын зөвлөл ажиллана. Зөвлөл нь Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

14.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллах ба хуулийн 84 дүгээр зүйлд заасан үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

14.3.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;

14.3.2. ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;

14.3.3. шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаад оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;

14.3.4. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

14.3.5. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;

14.3.6. эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарсанаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

14.4. Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 13.3.2-т заасан үүргийг хүлээнэ.

14.5. Албан тушаалтан энэ дүрмийн 13.2 болон 13.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурьдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

14.5.1. компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;

14.5.2. хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, бусад оролцогчдод хуурамч мэдээлэл гаргаж өгсөн;

14.5.3. эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;

14.5.4. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;

14.5.5. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгсөнөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

14.6. ТУЗ-ийн шийдвэрийн улмаас компанид хохирол учирсан бол уг шийдвэрийн эсрэг саналтай байсан болон тухайн асуудлыг шийдвэрлэсэн хуралд оролцоогүй гишүүн хариуцлагаас чөлөөлөгдөнө.

14.7. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь ТУЗ-ийн өмнө компанийн үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага хүлээнэ. Энэ дүрмийн 13.3-д заасныг зөрчин шийдвэр гаргасан албан тушаалтнууд хамтын хариуцлага хүлээх бөгөөд хохирлыг тэнцүү хэмжээгээр нөхөн төлнө.

14.8. Өөрийн буруугаас компанид хохирол учруулсан эрх бүхий албан тушаалтанд энэ хууль болон бусад хуульд заасан хариуцлагыг оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэж болно.

АРВАН ТАВ. ЗАРИМ ЧУХАЛ ХЭЛЦЭЛ

15.1. Их хэмжээний хэлцэл гэж дараах шаардлагыг хангасан нэг эсвэл холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлнэ:

15.1.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах, бусдад шилжүүлэх;

15.1.2. энэ дүрмийн 14.1.1-д заасан хэмжээний зээл өгөх, авах, барьцаа гаргах, батлан даалт гаргах;

15.1.3. компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах.

15.2. Их хэмжээний хэлцэлд компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон түүхий эд, материал авах, бэлэн бүтээгдэхүүнийг борлуулах хэлцэл хамаарахгүй.

15.3. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг ТУЗ тогтооно.

15.4. Компани тухайн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл, тэдгээрийн үнийн талаархи мэдээлэлийг нийтэд мэдээлэх үүрэгтэй

15.5. Сонирхолын зөрчилтэй хэлцэл /цаашид СЗХ гэнэ/ гэж энэ дүрмийн 13.1-д заасан компанийн эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдээс компанитай хийсэн гэрээ, хэлцлүүдийг хэлэх ба СЗХ-ийг ТУЗ-ийн хурлаар сонирхолын зөрчилгүй гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар шийвэрлэнэ.

15.6. Хэрэв ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд ХЭХ-д оруулж шийдвэрлэнэ.

15.7. Компани нь тухайн хугацаанд хийгдсэн СЗХ, тэдгээрийн үнийн талаархи мэдээлэлийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

15.8 Компанийн тухай хуулийн 89.4-т заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй холбоотой заалтууд (нэг талаас) компани, (нөгөө талаас) толгой компани эсхүл толгой компанийн харилцан холбоотой бусад компанитай хийсэн аливаа хэлцлийн хувьд хамаарахгүй.

/Энэ заалтыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 06 тоот тогтоолоор нэмсэн. /

АРВАН ЗУРГАА. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

16.1. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажлуулна. ТУЗ аудитын байгууллага, аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тогтооно.

16.2. Аудитын гэрээнд компанийн болон аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.

16.3. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.

16.4. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, түүний аудитийн хороо, эсхүл энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчийн шаардсанаар хэдийд ч хийж болно.

16.5. Аудитын байгууллагын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтын хөлсийг түүнийг захиалж, гэрээ байгуулсан

16.6. Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан нь тогтоогдовол шалгалтын хөлсийг бүрхүүтэй этгээд харууцан төлнө.

16.7. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

16.8. Энэхүү дүрмийн 15.7-д заасан үүрэгээ биелүүлээгүй албан тушаалтныг бүрхүүтэй аудиторын буюу аудиторын ажил зорссон хонот оногдох ажлын хөлсийг бүрхүүтэй этгээдээр төлүүлэх шийдвэрийг ТҮЗ гаргана.

16.9. Аудитор нь ХЭХ-д тайлбар өгөх үүрэгтэй оролцох эрхтэй. Аудиторын 94.13-д хориглоогүй этгээдийг компанийн аудитороор сонгон ажиллуулж болно. Энэхүү заалтыг зөрчиж аудиторыг сонгосон бол түүний аудитын дүгнэлтийг хүчингүйд тооцно.

16.11. Аудитын байгууллагын гаргасан дүгнэлтийн шинж чанараас хамааруулан олгох хөлсний хэмжээг тогтоохыг хориглоно.

16.12. Компанийн аудитор нь хуулийн 94.16-д заасан мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана.

16.13. Аудитын байгууллага нь өөрийн хийсэн аудитын дүгнэлтээс үүссэн хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

16.14. Компанийн дотоод хяналтын алба нь улирал бүр компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргаж Захирын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

16.15. Компанийн дотоод хяналтын албанаас компанийн бүх хэлтэс алба, хэсэг нэгжийг хамааруулан ээлжит шалгалтыг улирал бүр хийх бөгөөд тусгай хэсэг, үйлдвэрийн зөвшөөрсөн тохиолдолд тодорхой асуудлаар ээлжит бус шалгалт хийх эрхтэй.

АРВАН ДОЛОО. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ТАЙЛАН

17.1. Компанийн санхүүгийн жил, жил бүрийн 1 дүгээр сарын 1-нээс эхэлж, 12 дугаар сарын 31-нд дуусгавар болно.

17.2. Компани нь "Няглан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу няглан бодох бүртгэлээ хөтөлөн санхүүгийн тайлан гаргаж татварын байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж болон хуулиар заагдсан бусад байгууллагуудад хугацаанд нь хүргүүлнэ.

17.3. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

17.3.1. багас;

17.3.2. орлого үр дүнгийн тайлан;

17.3.3. мөнгөн гүйлгээний тайлан;

- 17.3.5. тайлангийн тайлбар тодруулга, илтгэх хуудас;
- 17.3.6. бүтээгдэхүүний өртгийн тайлан;
- 17.3.7. үйлдвэрлэлийн болон удирдлагын зардлын тайлан;
- 17.3.8. компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн биелэлт;
- 17.3.9. хуулийн 96.3-т заасан тайлангууд.

17.4. Энэ дүрмийн 16.3.1-16.3.5 дугаарт заасан тайлангуудыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр батлагдсан маягтын дагуу, 16.3.6-16.3.8 дугаарт заасан тайлангуудыг компанийн гүйцэтгэх удирдлагын баталсан маягтын дагуу, харин 16.3.9-т заасан тайланг хуулийн 96.3-т заасан эрх бүхий байгууллагаас гаргасан маягтын дагуу тус тус гаргана.

17.5. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

17.6. Компанийн санхүүгийн ажилтны бие даан гаргасан санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэгт алдаа гарсан тохиолдолд тухайн ажилтанд компанийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

17.7. Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд хуулийн 96.4-т заасан зүйлийг тусгана.

17.8. ТУЗ нь санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсны дараа компанийн үйл ажиллагааны тайлангийн хамт хэлэлцэн дүгнэлт гаргаж, ХЭХ-д оруулж хэлэлцүүлнэ.

АРВАН НАЙМ. КОМПАНИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХАДГАЛАХ

18.1. Компани нь хуулийн 97 дугаар зүйлийн 97.1, 97.2-т заасан баримт бичгээс гадна дараах баримт бичгийг хадгалж хамгаалах үүрэгтэй.

18.1.1. хувьцаа эзэмшигчдийн бүртгэл /тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл тоо, түүнд орсон өөрчлөлт/;

18.1.2. компанийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбогдсон баримт бичиг /эрх бүхий байгуулагатай харилцсан бичгийн бүрдэл, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ/;

18.1.3. аудитын байгуулагатай хийсэн гэрээ, холбогдох бусад баримт бичиг /гэрээ дүгнэсэн акт бусад/;

18.1.4. компани, компанийн салбар, төлөөлөгчийн газрын болон охин компанийн түүхэнд холбогдох баримт бичиг /түүхчилсэн лавлах, ном товхимол, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулан бэлтгэсэн баримт, бусад холбогдох баримт/.

18.2. Хуулийн 97.1.1, 97.1.3, 97.1.4, 97.1.6, 97.1.8, 97.1.11, энэ дүрмийн 17.1.1, 17.1.2, 17.1.4-д заасан баримт бичгийг байнга, бусад баримт бичгийг холбогдох хууль тогтоомжинд заасан хугацаагаар өөрийн архивт хадгалж хамгаална.

18.3. Компани нь хуулийн 97 дугаар зүйлийн 97.2-т заасан баримт бичгийг хадгалж, хуульд заасан эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах үүрэгтэй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн мэдэх, тэдний нэвтрэх боломж бүхий газарт хадгална.

18.4. Хуулийн 97.1-д заасан баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажиллагааг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ.

АРВАН ЕС. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

19.1. Компанийг өөрчлөн байгуулах тухай ойлголтод компанийг хуваах бусад компанитай нийлүүлэх, нэгтгэх, тусгаарлах, өөрчлөх асуудлууд хамаарагдана.

19.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг хуулийн 18-24 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэн шийдвэрлэнэ.

19.3. Компанийг хуульд заасан нөхцөл байдал үүсэхэд ХЭХ-ын шийдвэрээр хуульд заасны дагуу татан буулгана.

ХОРЬ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

20.1. Энэ дүрмийг монгол хэлээр тус бүр 3 хувь үйлдэж нотариатаар гэрчлүүлэн нэг хувийг Нотариатад, нэг хувийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт, нэг хувийг компани өөртөө хадгална.

20.2. Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.